



Засгийн газрын тохируулагч агентлаг
Стандарт, хэмжил зүйн газар

БАТЛАВ
БҮТЭЭГДЭХҮҮН, ТОГТОЛЦООНЫ
БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА

В.ГАНЗОРИГ

УКА0014
9090 (тэмдэг) 11713458 (Гарын үсэг)

2020 оны 03 сарын 02-ны өдөр

БАТАЛГААЖУУЛАЛТЫН ХАМРАХ ХҮРЭЭГ
ӨРГӨТГӨХ, БАГАСГАХ ЖУРАМ

СХЗГ-07-ББ-02(03):2020

Улаанбаатар хот

Бүртгэлийн дугаар:



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТЭС

ХУУЛБАР ҮНЭН

Хуулбар, өргөсгөл

Баримт бичгийн нэр:	БАТАЛГААЖУУЛАЛТЫН ХАМРАХ ХҮРЭЭГ ӨРГӨТГӨХ, БАГАСГАХ ЖУРАМ		
Баримт бичгийн тэмдэглэгээ/дугаар:	СХЗГ-07-ББ-02(03):2020		
Баталсан огноо:	2020.03.02	Баримт бичгийн хувилбар:	III

Баримт бичгийн түүх:


	Огноо	Овог нэр:	Албан тушаал:	Гарын үсэг:
Боловсруулсан:	2020.03.02	Дүгэрийн Чимгээ	БТБГ-ын ахлах мэргэжилтэн	
Хянасан:	2020.03.02	Дүгэрийн Чимгээ	БТБГ-ын ахлах мэргэжилтэн	
Хэлэлцүүлсэн огноо:	Хэлэлцсэн Хуралдаан: Ажлын хэсэг:		Хэлэлцүүлэгт оролцсон албан тушаалтан:	Албан тушаалтны гарын үсэг:
Хүчин төгөлдөр мөрдөж эхлэх хугацаа:	2020.03.02			

Хэвлэгдсэн хувь нь хуулбар хувь болохыг анхаарна уу.
Шаардлагатай тохиолдолд эх хувьтай тулган үзнэ үү.

Баримт бичгийн нэр:		БАТАЛГААЖУУЛАЛТЫН ХАМРАХ ХҮРЭЭГ ӨРГӨТГӨХ, БАГАСГАХ ЖУРАМ	
Баримт бичгийн тэмдэглэгээ/дугаар:		СХЗГ-07-ББ-02(03):2020	
Баталсан огноо:	2020.03.02	Баримт бичгийн хувилбар:	III

Агуулга

№	Гарчиг	Хуудасны дугаар
1	Зорилго	4
2	Хамрах хүрээ	4
3	Норматив эшлэл	4
4	Баталгаажуулалтын хүрээ өргөтгөх	4
5	Баталгаажуулалтын хүрээ багасгах	5



Баримт бичгийн нэр:	БАТАЛГААЖУУЛАЛТЫН ХАМРАХ ХҮРЭЭГ ӨРГӨТГӨХ, БАГАСГАХ ЖУРАМ		
Баримт бичгийн тэмдэглэгээ/дугаар:	СХЗГ-07-ББ-02(03):2020		
Баталсан огноо:	2020.03.02	Баримт бичгийн хувилбар:	III

1. Зорилго

Энэхүү баримт бичиг нь баталгаажуулагдсан үйлчлүүлэгчдийн бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ, үйл явц, менежментийн тогтолцоо /цаашид бүтээгдэхүүн гэх/-ны баталгаажуулалтын хамрах хүрээг өргөтгөх багасгах, өргөтгөх үйл ажиллагаанд хамаарна.

2. Хамрах хүрээ

Стандарт, хэмжил зүйн газрын Бүтээгдэхүүн, тогтолцооны баталгаажуулалтын газар, түүний харъяа орон нутгийн баталгаажуулалтын байгууллага болон гэрчилгээ эзэмшигч байгууллагууд хоорондын хүлээн зөвшөөрөх гэрээнд заасан бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл явц, менежментийн тогтолцоонд хамаарна.

3. Норматив эшлэл

-Тохирлын үнэлгээ — Бүтээгдэхүүн, үйл явц болон үйлчилгээг баталгаажуулах байгууллагад тавих шаардлага. MNS ISO/IEC 17065:2013;

-Монгол Улсад бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний баталгаажуулалтыг схемийн дагуу явуулах нийтлэг журам. /СХЗГ-ын даргын 2018 оны А/254 тоот тушаалын хавсралт/

- Тохирлын үнэлгээ – Менежментийн тогтолцооны аудит болон баталгаажуулалт явуулдаг байгууллагад тавих шаардлага MNS ISO/IEC 17021-1:2020

-Тохирлын үнэлгээ- Бүтээгдэхүүний хөндлөнгийн баталгаажуулалтын тогтолцоог ажиллуулах заавар.MNS ISO Guide 28:2008

-Менежментийн тогтолцооны баталгаажуулалтын журам.

4. Баталгаажуулалтын хүрээг өргөтгөх

4.1 Баталгаажуулагдсан үйлчлүүлэгч нь бүтээгдэхүүний зохион бүтээлт, үйлдвэрлэлд нэвтрүүлсэн шинэ технологи, тоног төхөөрөмжийн шинэчлэлт, салбар компани байгуулсан зэргээс хамаарч баталгаажуулалтын хүрээг өргөтгөх хүсэлтийг баталгаажуулалтын байгууллагад гаргана.

4.2 Баталгаажуулагдсан үйлчлүүлэгч нь бүтээгдэхүүн /үйлчилгээ, үйл явц, менежментийн тогтолцооны хамрах хүрээг өргөтгөх тухай хүсэлтийг баталгаажуулалтын байгууллагаас гаргасан өргөдлийн маягтын дагуу гаргаж ирүүлнэ.

4.3 Магадлах аудиттай хамтруулан хүрээг өргөтгөх аудитыг хэрэгжүүлж болно.

4.4 Өргөдөл гаргагч нь бүтээгдэхүүний зохион бүтээлт, үйлдвэрлэлд нэвтрүүлсэн шинэ технологи, тоног төхөөрөмжийн шинэчлэлт, салбар компани, хүрээг өргөтгөхөд хамаарах тухайн бүтээгдэхүүнтэй холбогдол бүхий тодорхойлолт, материалыг өргөдөлд хавсаргасан байна.

4.5 Баталгаажуулалтын байгууллага ажлын хэсгийг томилж, ирүүлсэн баримт бичигт дүн шинжилгээг явуулах ба шаардлага хангасан тохиолдолд холбогдох схемийг сонгон өмнөх баталгаажуулалтын ажлыг давтахгүйгээр хүсэлт гаргасан тухайн бүтээгдэхүүн /объект/-д үнэлгээ/аудит/-г явуулна. Магадлах аудиттай хамтруулан хүрээг өргөтгөх аудитыг хэрэгжүүлж болно.

4.6 Тохирлын үнэлгээний дүнгээр үл тохирол илэрвэл заасан хугацаанд залруулах шаардлагыг тавина.

4.7 Үл тохирлыг залруулах хугацаа нь 3 сараас илүүгүй байна.

4.8 Залруулах ажиллагаа гурван сараас хэтэрсэн тохиолдолд тухайн объектод явуулсан үнэлгээ нь хүчингүйд тооцогдоно.

Хэвлэгдсэн хувь нь хуулбар хувь болохыг анхаарна уу.

Шаардлагатай тохиолдолд эх хувьтай тулган үзнэ үү.

Баримт бичгийн нэр:	БАТАЛГААЖУУЛАЛТЫН ХАМРАХ ХҮРЭЭГ ӨРГӨТГӨХ, БАГАСГАХ ЖУРАМ		
Баримт бичгийн тэмдэглэгээ/дугаар:	СХЗГ-07-ББ-02(03):2020		
Баталсан огноо:	2020.03.02	Баримт бичгийн хувилбар:	III

4.9 Хэрэв тохирлын үнэлгээний дүнгээр үл тохирол илрээгүй бол хамрах хүрээг өргөтгөх саналыг Баталгаажуулалтын зөвлөлийн хурлаар оруулж хэлэлцүүлэн холбогдох шийдвэрийг гаргуулна.

4.10 Баталгаажуулалтын зөвлөлийн хурлаас гарсан шийдвэрийг үйлчлүүлэгчид мэдэгдэх ба эерэг гарсан тохиолдолд гэрчилгээг олгож, бүртгэнэ.

4.11 Баталгаажуулалтын байгууллага нь гэрчилгээ эзэмшигчтэй "Гэрчилгээ болон стандартын тэмдэглэгээг хэрэглэх тухай гэрээ"-г байгуулан ажиллана.

4.12 Гэрээнд гэрчилгээ эзэмшигч ба баталгаажуулалтын байгууллагын эрх үүрэг, гэрчилгээний хугацаа, хамрах хүрээ, гэрчилгээ эзэмших, эрхийг түр зогсоох, хүчингүй болгох, магадлах хяналт, давтан үнэлгээг явуулах, ажил үйлчилгээний төлбөрийн нөхцлүүдийг тусгана.

5. Баталгаажуулалтын хамрах хүрээг багасгах

5.1 Баталгаажуулалтын хамрах хүрээний нэг хэсэг баталгаажуулалтын шаардлагыг байнга буюу ноцтой зөрчиж байгаа тохиолдолд Баталгаажуулалтын байгууллагаас шаардлага хангахгүй байгаа тэдгээр хэсгийг хасаж, үйлчлүүлэгчийн баталгаажуулалтын хүрээг багасгана.

5.2 Үйлчлүүлэгчийн баталгаажуулалтын хүрээг багасгах асуудлыг Баталгаажуулалтын зөвлөлийн хуралд үнэлгээг явуулсан ажлын хэсэг оруулж хэлэлцүүлэн холбогдох шийдвэрийг гаргуулна.

5.3 Баталгаажуулалтын зөвлөлийн хурлаас гарсан шийдвэрийг үйлчлүүлэгчид мэдэгдэх ба баталгаажуулалтын хамрах хүрээг багасгасан тохиолдолд өмнөх гэрчилгээг хураан авч, гэрчилгээг шинээр бичиж олгон, бүртгэнэ.

5.4 Баталгаажуулалтын байгууллага нь гэрчилгээ эзэмшигчтэй "Гэрчилгээ болон стандартын тэмдэглэгээг хэрэглэх тухай гэрээ"-г шинээр байгуулан ажиллана.

5.5 Баталгаажуулалтын байгууллага нь баталгаажуулагдсан үйлчлүүлэгчийн гэрчилгээний хамрах хүрээнд орсон өөрчлөлтийг "Баталгаажуулагдсан үйлчлүүлэгчийг бүртгэх, мэдээлэх журам"-д заасны дагуу нийтэд мэдээлнэ.

5.6 Баталгаажуулалтын хамрах хүрээг багасгасан үед үйлчлүүлэгч нь баталгаажуулалтыг цаашдын сурталчилгаандаа хэвээр хадгалбал, Баталгаажуулалтын байгууллагаас албан шаардлагыг хүргүүлнэ.

6. Баталгаажуулалтын шийдвэр, мэдээлэл

6.1 Баталгаажуулалтын байгууллагын дэргэдэх орон тооны бус Баталгаажуулалтын зөвлөл нь бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл явц, менежментийн тогтолцоонд явуулсан үнэлгээ, дүгнэлтийг хэлэлцэж баталгаажуулалтын хамрах хүрээг өргөтгөх, багасгах шийдвэрийг гаргана.

6.2 Баталгаажуулалтын зөвлөлийн гаргасан шийдвэрийг "Баталгаажуулалтын гэрчилгээ олгох, хадгалах, хугацаа сунгах, гэрчилгээ цуцлах журам"-ын хавсралтын дагуу бүртгэнэ.

6.3 Баталгаажуулалтын байгууллага нь баталгаажуулагдсан үйлчлүүлэгчийг "Баталгаажуулагдсан үйлчлүүлэгчийг бүртгэх, мэдээлэх журам"-д заасны дагуу нийтэд мэдээлнэ.

Төгсөв

Хэвлэгдсэн хувь нь хуулбар хувь болохыг анхаарна уу.
Шаардлагатай тохиолдолд эх хувьтай тулган үзнэ үү.

Бүртгэлийн дугаар:

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТЭС

ХУУЛБАР ҮНЭН